



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/78

Булган сум

Цусны доноруудад хүндэтгэл үзүүлэх тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дүгээр зүйлийн 60.1.2, Донорын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, цус цусан бүтээгдэхүүний нөөцийг нэмэгдүүлэхэд идэвх санаачилга гарган цусаа бэлэглэж бусдыгаа аврах үйлдэлд талархал илэрхийлэн хүндэтгэл үзүүлсүгэй.

2. Хүндэтгэлийн зардалд шаардлагатай 3,300,000 (гурван сая гурван зуун мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ЛҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2025 оны
02 дугаар сарын 22-ны/ний өдрийн 4/76 дүгээр
захирамжийн хавсралт

Цусны доноруудад хүндэтгэл үзүүлэхэд шаардагдах зардал

д/д	Зориулалт	Тоо/ш	Үнэ	Нийт
1	2	3	4	5
1	Витамин багц	50	66,000	3,300,000